



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2011 оны 01 сарын 14 өдөр

Дугаар 18


Улаанбаатар хот

Томуу, томуу төст өвчинтэй тэмцэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай

Улсын хэмжээнд томуу, томуу төст өвчин нэмэгдэж байгаатай холбогдуулан ТУШААХ нь:

1. Томуу, томуу төст өвчинтэй тэмцэх арга хэмжээг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.
2. Томуу, томуу төст өвчний цагийн байдалд дүгнэлт хийж, шаардлагатай арга хэмжээг шуурхай зохион байгуулан мэдээ, мэдээллээр холбогдох байгууллагуудыг ханган ажиллахыг Эрүүл мэндийн дэд сайд, ажлын хэсгийн ахлагч Ж.Цолмонд даалгасугай.
3. Томуу, томуу төст өвчин амбулаторийн нийт үзлэгийн 15-20 хувьд хүрсэн тохиолдолд түргэн тусламжийн машин, өрхийн болон амбулаторийн эмч нарын тоог нэмэгдүүлэн уртасгасан цагаар ажиллуулахыг Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.
4. Томуу, томуу төст өвчний эрсдэлт бүлэг болох жирэмсэн эмэгтэйдүүд, 6 сартайгаас 5 насны хүүхдүүд, уушгийн архаг өвчтэй хүмүүст тавих өрхийн эмчийн хяналтыг сайжруулан томуугийн эсрэг дархлаажуулалтад эрчимтэй хамруулахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв/Д.Нямхүү/, Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.
5. Томуу, томуу төст өвчний сэжигтэй өвчтнүүдэд лабораторийн шинжилгээний хариуг хүлээлгүйгээр вирусийн эсрэг тамифлу эмийг хэрэглэхийг бүх шатны Эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.
6. Томуу, томуу төст өвчний хүндрэлээс сэргийлэн эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг ханган ажиллахыг Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, клиникийн болон төрөлжсөн нарийн мэргэжлийн төвийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.
7. Томуу, томуу төст өвчний талаар хүн амд зориулсан мэдээлэл, сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр эрчимтэй явуулахыг ЗГХА-ЭМГТ-ийнх нь даалгасугай.
8. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэдээлэл, хяналт-шигшмэлгээ үнэлгээний газар (С.Энхболд)-т даалгасугай.

С.ЛАМБАА



Эрүүл мэндийн сайдын 2011 оны 18... тоот тушаал үрхэвсрэлт

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Цолмон, Эрүүл мэндийн дэд сайд

Нарийн бичгийн дарга: Я.Амаржаргал, ЭТБХЗГ-ын орлогч дарга

Гишүүд:

С.Төгсдэлгэр, НЭМБХЗГ-ын дарга

Б.Хонгорзул, МХШҮГ-ын орлогч дарга

Д.Нарангэрэл, НЭМБХЗГ-ын мэргэжилтэн

Г.Соёлгэрэл, ЭТБХЗГ-ын мэргэжилтэн

Я.Буянжаргал, ЭТБХЗГ-ын мэргэжилтэн

Ё.Мөнхтуул, СХОГ-ын мэргэжилтэн

Ц.Хун, ЗГХА-ЭМГ

С.Туул, Нийслэлийн ЭМГ-ын дарга

Д.Нямхүү, ХӨСҮТ-ийн ерөнхий захирал

Ц.Гүрээдаш, Нийслэлийн яаралтай тусламжийн төвийн дарга